

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 15 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулан, 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг дэмжих арга хэмжээний санал боловсруулах сургалт, хэлэлцүүлэгийг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, аймгийн ИТХ-ын дарга Ш.Билэггүмбэрэл, аймгийн орлогч дарга Б.Наранбаатар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэлтсийн дарга, агентлагийн удирдлагууд, орон нутагт шилжиж ирсэн иргэдийн төлөөлөл, баялаг бүтээгчдийн холбоо, худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл гээд нийт 50 гаруй хүн оролцлоо.

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Монгол улсад Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн баярыг энэ сарын 13-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Ойн арга хэмжээний үеэр Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 4, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 17, Цэргийн гавьяаны одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 11, Цэргийн хүндэт медалиар 1, Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар 44, Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Говьсүмбэрийн төлөө медаль"-иар 48 иргэн, аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр 2, Монголын нутгийн удирдлагын холбооны дээд шагнал "Соёмбо одон"-оор 3, Өргөмжлөлөөр 4 иргэн тус тус шагнагдсан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2023 оны 01 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 797 710 мян төгрөг, гүйцэтгэлээр 343 156,4 мян төгрөг буюу 43%, үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 119 075 мян төгрөг, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 627 110 мян төгрөг төвлөрүүлэхээс 151 926 мян төгрөг буюу 24.22%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 170 600 мян төгрөг төвлөрүүлэхээс 72 155,4 мян төгрөг буюу 42.3%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 698 хуулийн этгээд бүртгэлтэй байна. Үүнд: ХК 1, ХХК 365, ББН 5, ЗБН 9, Хоршоо 29, ХЗХоршоо 1, ОНӨҮГ 6, Салбар 66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ216 байна.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 75 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан ба 12 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 95.5 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд манай байгууллагад 122 766,9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 102 346,6 мянган төгрөгийг зарцуулж 20 420,2 мянган төгрөг хэмнэсэн байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төрийн архив: Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1 хөмрөгийн 4 хадгаламжийн нэгж, 309 заалт, 1299 хүний нэр, 309 байгууллагын нэр, 927 газарзүйн нэр, 493 хуудас баримтыг программд холбож ажилласан. 2023 оны 01 дүгээр сард 14 иргэнд лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 оны 10 дугаар сард дараах чиглэлээр нийт 743 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 101
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 33
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 32
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 2
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 0
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 40
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо – 57
- Тоон гарын үсэг олгосон - 45

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 8
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 10
- Гэрээний бүртгэл - 18
- Барьцааны гэрээний бүртгэл - 97
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 2

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 5

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 95
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 12
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 176

Хууль сахиулах чиглэлээр: Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 107 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 35, зөрчлийн 72 гомдол мэдээлэл байна. Зөрчил үйлдсэн 22 иргэнийг 4 100 000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 12 хүнийг эрүүлжүүлж, 10 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 22 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 115 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллаж байна.

01 дүгээр сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 4, видео шторк 31, бусад төрдийн мэдээлэл 5, нийт 40 мэдээллийг цахимаар хүргэсэн байна.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 24 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 3, зам тээврийн ослын 2, хулгайлах гэмт хэрэг 2, бусад 1. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 387 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Онцгой байдлын газар нь: Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гал түймрийн объектын зөрчлийн дуудлага 3, эрэн хайх, аврах ажиллагааны 1 дуудлага бүртгэгдсэн байна. Гэр хорооллын айл өрх, худалдаа, олон нийт, үзвэр үйлчилгээний барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулав. Газар дээр нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн 28 зөрчлийг арилгуулан ажилласан.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Сургуулийн өмнөх боловсролын 7 цэцэрлэгийн 56 багшид “Хүүхдийн эрүүл мэнд, хувийн ариун цэвэр, зохистой хооллолт” сэдвээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

Бага насны хүүхдийн бие даан тоглох орчинг бүрдүүлэх, хоцрогдож байгаа агуулга ба чадвараа тоглоомоор дамжуулан хүүхэд бүрт хүрч хэрэгжүүлэх, сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “МИНИЙ СУРГАЛТЫН ОРЧИН” сэдэвт сургалтын хэрэглэгдэхүүний үзэсгэлэнг гаргасан.

Залуу багш нарыг чадавхжуулах зорилгоор, үнэлгээний шинжээч, сургалтын менежерүүдтэй хамтран “Үнэлгээний шалгуур, үнэлгээний төрөл хэлбэр” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтаад нийт 62 багш хамрагдсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын хэсгийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын тушаалаар томилж, хуралдуулан 2023 оны ажлын төлөвлөгөөнд санал авч, “Алхам алхамаар 6 долоо хоногийн аян” -ныг хамтран зохион байгуулах ажлын чиглэлийг хэлэлцлээ.

Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хоол зүйч, тогооч, эмч, хоол үйлвэрлэл, үйлчилгээний ажилчдад “ХҮҮХДИЙН ХООЛНЫ ЖОР” сэдвээр сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 49 албан хаагч хамрагдлаа.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Ерөнхийлөгчийн цомын төлөөх Усанд сэлэлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнд "Говийн Усчид" клубийн 22 тамирчин 2 дасгалжуулагч оролцож, 3 алт, 12 мөнгө, 12 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр 6 дугаар байрт шалгарсан.

Мөн Дорноговь аймагт зохион байгуулагдсан "САЙНШАНД -2023" холимог насны боксчдын аварга шалгаруулах олон хотын тэмцээнд 10 тамирчин оролцож, 1 алт, 3 мөнгө, 3 хүрэл медаль хүртлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2022 оны 01 сар	2023 оны 01 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	31	22
Гэрийн төрөлт	0	1
Амьд төрсөн хүүхэд	31	22
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	6	4
Эмнэлгийн нас баралт	2	2
Хоног болоогүй нас баралт	1	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	645	140
Амбулаторийн үзлэг	8487	6683
Халдварт өвчин	1132	7

Гэмтэл согог судлалын үндэсний төвд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэмжих төвийн 8 ажилтанг туршлага судлуулж, сэлгэн ажиллуулсан.

Өрхийн эрүүл мэндийн төвөөс хөдөөгийн багийн малчид болон отороор нутаглаж байгаа иргэдэд явуулын эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд, нийт 108 иргэн хамрагдсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил хайгч, бүртгэлтэй 11 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 20 иргэнд нээлттэй ажлын байрны зар мэдээлэл, ажилд хэрхэн бүртгүүлэх талаар мэдээлэл хүргэж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

2019-2022 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдан эргэн төлөлтийн хугацаа хэтрүүлсэн иргэдтэй уулзаж, авлага барагдуулах, зөвлөмж өгөх, мэдэгдэл хүргүүлэх ажлыг зохион байгуулж, 149 иргэний эргэн төлөлтөд хяналт тавин давхардсан тоогоор 108 иргэний 25140,0 мян төгрөгийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” санд төвлөрүүлэн ажилласан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг аймгийн хэмжээнд 56 өрхийн 280 гишүүнд олгосон.

2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 20 иргэнд “Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх журам”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд”, “Нээлттэй ажлын байрны зар мэдээлэл, ажилд хэрхэн бүртгүүлэх” талаар тус тус мэдээлэл хийсэн.

Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр 01-ний өдрөөс эхлэн төрийн 5 байгууллагын /Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын татварын алба, Авто тээврийн үндэсний төв/ мэдээллийн сантай тулгалт хийж нийт хүүхдийн 91%-д олгохоор болсны дагуу аймгийн хэмжээнд 6390 хүүхдэд мөнгөн тэтгэмжийг олгоод байна. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн зөрүүтэй байдлын уялдаа, холбоог зохицуулах, иргэдийг зөв мэдээллээр хангах, гомдол саналыг шуурхай шийдвэрлэх ажлын хүрээнд 01 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд утсаар-953 иргэн, биеэр-260 иргэн нийт 1213 иргэнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар зөвлөгөө өгч, мэдээллийг шалгасан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн хэмжээнд нийт 954,948 толгой мал өвөлжиж байгаагаас манай аймгийн 464203 толгой мал, аймаг дундын Малах отрын бүсэд Төв аймгийн 5 өрхийн 5021 мал, мөн зөвшөөрөлгүй оторлож байгаа Өвөрхангай аймгийн 2 сумын 5 өрхийн 5.3 мян.мал, Дундговь аймгийн 2 сумын 5 өрхийн 4.6 мян.мал, Төв аймгийн 2 сумын 5 өрхийн 4.5 мян.мал, Хэнтий аймгийн Дархан сумын 4 өрхийн 2.1 мян мал өвөлжиж байна

Отрын бүсээс гадна Баянтал, Сүмбэр сумын нутгаар отрын 14 өрхийн 22.8 мян толгой мал зөвшөөрөлгүй ирж, өвөлжиж байна. Бэлчээрт идэш хомсдож, нутгийн малчдын өвс, тэжээлийн нөөц тооцоолсноос илүү зарцуулан, 3-4 дүгээр сард хүрэлцээгүй болох магадлал өндөр байна.

Хүнсний нөөц: Аймгийн дүнгээр мах 60 тн буюу 20, гурил 42 тн буюу 45, сүү 2.8 тн буюу 1, төрөл бүрийн будаа 21 тн буюу 29, төмс 20 тн буюу 12, хүнсний ногоо 18 тн буюу 6, элсэн чихэр 8.2 тн буюу 18, давс 5.4 тн буюу 18, савласан ус 25 тн буюу 1, өндөг 1.7 тн буюу 11, ургамлын тос 6.2 тн буюу 22 хоногийн нөөцтэй байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2023 оны 01-р сарын үнийн мэдээ:

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 10-700 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: Адууны мах 500 төгрөгөөр, лууван 150 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр, чинжүү 700 төгрөгөөр, элсэн чихэр 200 төгрөгөөр,

өргөст хэмх 500 төгрөгөөр, сонгино 150 төгрөгөөр, элсэн чихэр 100 төгрөгөөр, будаа 150 төгрөгөөр, өндөг 10 төгрөгөөр, гурил /алтан тариа 1кг/ 100 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй малын мах төрөл тус бүрээр 250 төгрөгөөр, төмс, хүнсний ногоо 50-250 төгрөгөөр, сүү 500 төгрөгөөр, гурил 200 төгрөгөөр буурсан бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 300 төгрөгөөр, цагаан будаа 250 төгрөгөөр, ургамлын тос 1500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	Ястай	9000	8500	
		Цул	10500	10500	
2	Хонины мах	Ястай	6500	6000	
		Цул	8000	7500	
3	Адууны мах	Ястай	7000	7000	
		Цул	9000	9000	
4	Ямааны мах	Ястай	5500	4500	
		цул	6000	6000	
5	Тахианы мах	Гуя	12000	10500	
		мөч	14300	11000	
6	Лууван	монгол	2000	1700	
		хятад			
7	төмс	монгол	1500	1500	
		хятад			
8	Байцаа	монгол	2100	2000	
		хятад			
9	чинжүү	монгол			
		хятад	10000	8500	
10	Манжин	монгол	3500	3000	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3000	2800	
		Хятад			
12	Помидор	монгол	-	-	
13	Өргөст хэмх	монгол	11000	10000	
14	Элсэн чихэр	монгол	3500	3200	
15	Будаа	Цагаан задгай кг	4000	3500	
		Шар слава кг	5100	3000	
		Гурвалжин будаа кг	6000	4000	
16	Сүү	Задгай	3000	2800	
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	4300	4000	
17	Тараг	Задгай	3500	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	5500	4200	
18	Талх	Чойр талх	2000	1950	
19	Өндөг	ОХУ	550	500	
		Монгол	580	500	
		Задгай дээд	1500	1300	

20	Алтан тарианы гурил	Задгай 1-р зэрэг	2300	2000	
		Задгай 2-р зэрэг	1400	1000	
		Савласан д/дээд /	2700	2500	
		Савласан дээд	2200	1800	
		Савласан 1-р зэрэг	1950	1400	
		Савласан 2-р зэрэг	1200	1000	
21	Ургамлын тос	Олейна	10800	10500	
		Алтан	8000	7500	
22	Гоймон	Алейка	2000	2000	
		А/тариа савхан	1700	1500	

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин, аялал жуулчлалын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ховор амьтан болох аргаль хонинд зориулан биотехникийн арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай Чойрын богд ууланд 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгууллаа. тус арга хэмжээний хүрээнд 1,5 тонн хужрыг зэрлэг амьтдын байршиж буй 4 байршил газарт тараан байрлуулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: 2023 оны 01 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд Газрын багц хуулийн хэлэлцүүлэгийг зохион байгуулсан бөгөөд аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, газар, хэлтэс агентлагийн дарга нар мөн иргэдийн төлөөлөл зэрэг нийт 489 хүн танхимаар, 31 иргэн цахимаар саналаа өгч, нийт 520 иргэн санал өгсөн байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 онд нийт 2,930,781.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,807,509.3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 3төсөл арга хэмжээ, Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 1,807,509,3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээ, Аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440,616.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил, Аймгийн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөөд байна.

Баянтал сум: 2023 оны 01 дүгээр сарын 17- 19-ний өдрүүдэд малчдад 54 шуудай тэжээл тараасан.

2022 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогыг Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/112 дугаар захирамжаар хүн амын тооллогыг зохион байгуулсан. Малын тоо өмнөх оноос 6708 тоо толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.

Төв аймгийн Баян сумын 1 өрх, Дундговь аймгийн 6 өрхийн нийт 16500 гаруй толгой мал отроор ирж өвөлжиж байгаа бөгөөд тус айлуудад бэлчээр чөлөөлөх тухай сумын Засаг даргын албан мэдэгдэл хүргүүлсэн.

Шивээговь сум: Аймгийн Онцгой байдлын газраас сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалт, дадлага”-ыг зохион байгууллаа. Сургалтаар Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн онолын мэдлэг олгохоос гадна төөрсөн үед байршил тогтоох what3word программ ашиглах, өрхийн эрсдэлийн үнэлгээ хийх, үерийн гамшгийн үед өөрсдийн нөөц боломжоор далан босгох, объектын болон хээрийн түймэр унтраах талаар бүлгийн дадлага сургуулийг хийсэн.

Монгол Улс Үндсэн хуулиа баталж, хэрэгжүүлсний 31 жилийн ойн баярын хүрээнд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ гардан авсан 8 сурагч “Иргэний андгай” өргөсөн.

Сүмбэр сум: Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд багийн Засаг даргын тодорхойлолтыг 206 иргэнд, хөнгөлөлт тусламж 10 иргэнд хүргэж, **ХАӨМС**-ын программын өрхийн алдааг засан, шинээр төрсөн хүүхэд болон нас барсан, шилжиж ирсэн, шилжиж явсан хүмүүсийн мэдээллийг программд тухай бүр бүртгэж, хасалт хийж ажилласан.

2023 оны 01 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд Энхтусдэм өрхийн эмнэлэгтэй хамтран 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч өвөлжилтийн цаг үеийн байдалтай танилцаж, 0-2 настай хүүхэд, өндөр настай иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо, товлолийн болон томуугийн вакцин, элэгний ВС, Хеликобактер, Сахар, Холстрен, Сериологийн түргэвчилсэн шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг, mobile Эхо үйлчилгээнд 51 өрхийн 108 иргэн болон отроор өвөлжиж байгаа 6 өрхийн 22 иргэнийг хамруулсан.

2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр отроор ирсэн 6 өрхөд сумын Засаг даргын албан мэдэгдлийн дагуу хугацаандаа нүүх талаар сануулж, бэлчээр ашиглалтын журмыг танилцуулсан.

Бог малын гоц халдварт мялзан өвчний шинж тэмдэг илэрч баталгаажсантай холбогдуулан 01 сарын 06-ны өдрөөс эхлэн хяналтын 2 пост байгуулан ажиллаж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР